



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/375

Улаанбаатар хот

Хот нийтийн аж ахуйн зарим ажил үйлчилгээнд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоол, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Хот нийтийн аж ахуйн зарим ажил үйлчилгээнд хяналт тавих тухай 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/199 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, орчны тохижилт, гадна фасад, зар сурталчилгааны байгууламж, хаягийн байгууламжийн өнгө үзэмжийн байдал, нийтийн аж ахуйн чиглэлээр хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар, дэд ажлын хэсгийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүүргийн нутаг дэвсгэрт цас орсон даруйд хариуцсан гудамж, зам талбайн цасыг зориулалтын техник хэрэгслээр шүүрдэж, хусах, нөөцөлж бэлтгэсэн, давс, бодис, элс, дайргыг цацах, явган хүний зам талбайн цасыг нягтаршиж хатуурахаас өмнө цэвэрлэх, авто зам, замын байгууламжид бодис давсны үйлчлэлээр цастай холилдсон үлдэгдлийг ногоон байгууламж, мод бутны нүхэнд асгахгүйгээр цуглуулж, тээвэрлэхийг Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг сурталчилан, тайлагнах асуудлыг хариуцан зохион байгуулахыг Хэвлэл, мэдээллийн алба /Д.Цэнгэлмаа/, Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан Төслийн удирдагч-Засаг даргын орлогч Т.Батцогт нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ